

"МОНГОЛ ЦААЗЫН БИЧИГ"-ИЙГ МӨШГӨН ШИНЖИЛСЭН ХОЁР БҮТЭЭЛИЙН ТУХАЙ БЯЦХАН ШҮҮМЖ

З.Лонжид

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

Түүх судлаачид аливаа бичмэл сурвалжийг "уламжлалт", "үлдэгдэл зүйл" хэмээн хоёр ангилдаг билээ /1.6/ Эдгээрээс уламжлалт сурвалж нь тухайн үедээ төр засаг, эрх мэдэлтэн буюу аль нэгэн субъектээс тодорхой зорилгоор боловсруулан дагаж шийтгүүлж байсан баримт бөгөөд тэр нь зохих хугацааны дараа буюу үргэлжлүүлэн хэрэглэх шаардлагагүй болсноосоо хойш судалгааны эх сурвалж болгон ашиглахаас өөр хэрэгцээгүй болно. Аль ч улс үндэстэн эх түүхээ нэхэн судлахдаа тулгуурладаг гол эш хэрэглэхүүн нь бичгийн янз бүрийн сурвалж ялангуяа анхдагч сурвалж байдаг.

XVI зууны хориод оноос хойшх Монголын түүхийг цогц байдлаар шинжилж үнэмшилтэй дүгнэлт гаргахад ашиглахгүй байж ер боломгүй олон сурвалж байдаг бөгөөд тэдгээрийн нэг бол Хойд Алтан Улс 1620-иод оноос эхлэн ашиг хичээж өөрт нь дотносож гэр бүл, үр, хөвгүүд, харъяат нараа авч уван цуван дагаар орох болсон Монголын дорно хязгаарын зарим ноёд ба 1634 онд улсынхаа эзэн хаан Лигдэнг таалал төгссөнөөс хойш жил гаруйхны дараа одоогийн Мүгдэн хотноо чуулж, тус улсын хаан Абахайг Монголын хаан хэмээн өргөмжилсөн дорнод монголын арван зургаан аймгийн дөчин өсөн ноёдыг Алтан улсын төр ихээхэн сайшааж янз бүрээр урамшуулан шагнаж худ ураг болцгоож, аль болох элгэмсэг дотно хандаж байлаа. Хойд Алтан Улсын хаан тэр жил буюу 1636 онд зарлиг буулгаж, улсынхаа нэр өөрийн цолоо халж манж Дайчин улс Дээд эрдэмт хаан хэмээн шинэчилсэн төдийгүй өөртөө дагаар орсон монгол ноёд, тэднийг дагалдагчид, эгэл иргэдийг журамлан захирч байх тусгай хууль цааз боловсруулан мөрдүүлж байсан буй за.

Манж Дайчин Улсаас монголчуудыг захирахад зориулсан анхны тийм хууль бол "Монгол цаазын бичиг" /цаашид МЦБ гэж товчилно/ байсан байж тун магадгүй. Тэгэхдээ МЦБ-ийг чухамыг 1636 оноос дагаж шийтгүүлсэн гэдгийг шууд ба дам нотлохуйц сурвалжийг одоо хир илрүүлж амжаагүй боловч 1643 оноос уг хуулийг албан ёсоор тархаасан гэж Өвөр монголын түүхчид 1989 онд хэвлүүлсэн хамтын бүтээлдээ анх тэмдэглэсэнээс үзвэл МЦБ-ийг гэв гэнэт 1643 онд боловсруулчихаагүй харин түүнээс өмнө буюу Монголын дорнод хязгаарын олон ноёд Абахайг өөрийн эзэн хэмээн дагаар орсон тэр үеэс буюу 1636 оноос эхлэн тэднийг зохицуулан журамлах эрх зүйн буюу цааз эрхэмжийн ямар нэгэн шийдвэрийг Манжийн төр гаргасан байх ёстой. Тодруулж хэлбэл 1636 онд өөрт нь дагаар орсон ноёдод өндөр цол зэрэг хэргэм, албан тушаал, нутаг дэвсгэр шагнал хүртээсний сацуу тэднийг захирч байх ямар нэгэн дүрэм журам боловсруулж мөрдүүлэлгүй өөрсдийнх нь дураар сул зоргоороо байхыг зөвшөөрөөгүй нь мэдээж.

Миний таамаглаж байгаагаар бол 1636 оноос эх үүсвэртэй, өвөр монголын эрдэмтэдийн нотолсноор 1643 оноос эхлэн дагаж шийтгүүлсэн МЦБ, түүнээс хожуу боловсруулсан "Зарлигаар тогтоосон Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг" /цаашид ЗТГМТЗЯЯХЗБ гэж товчилно/ хоёр нэг хууль уу эсвэл тус тусдаа өөр хууль юм уу гэдэг талаар судлаачид харилцан адилгүй үзэл бодолтой байдаг бөгөөд цөөнгүй судлаачид энэ хоёр бол нэг хууль харин хоёр өөрөөр нэрлэдэг байсан бололтой гэж бичсэн байдаг. Зарим эрдэмтэд МЦБ бол ЗТГМТЗЯЯХЗБ-ээс урьд боловсруулсан ондоо хууль гэж үзэж байгаа юм. Миний бодоход хоёр дахь санал нилээд үндэслэлтэй юм. Үүнийгээ тайлбарлаж хэд гурван үг хэлэх нь зүйтэй байх. Тухайлбал, 1789 оноос дагаж шийтгүүлсэн боловч дараа нь хэд хэдэн удаа нэмж өөрчилсөн ЗТГМТЗЯЯХЗБ

хэмээх 1544 зүйл бүхий чанд хатуу заалттай энэхүү хуулийг баримтлан монголын төр, захиргаа, нутаг дэвсгэр, алба татвар, шашин шүтлэг, эрүү, иргэний бүх хэрэг явдлыг 1911 он хүртэл шийдвэрлэж байлаа. Нөг зуу гаруй жилийн турш мөрдсөн энэ хуулийн гол агуулга нь МЦБ-ийн үндсэн заалтуудад тулгуурласны сацуу нилээд зүйлийг шинээр нэмж зарим ялын хэмжээг харийн тодорхой болгож монгол хүн хэн боловч "тэнгэрийн болсноор цагийг эвэлсэн" их Дайчин улсын төрд өчүүхэн төдий төрөлх аяаас ямар ч зориолгүйгээр зохих ял эдгэх буюу цээрлэл шийтгэл хүлээх ёстойг санхирүүлэн мэдүүлэхэд онцлон анхаарч байлаа. Өөрөөр хэлбэл, 1620-иод оноос эхлэн Манжийн тэр мөнхх хүртлээ Монголын ихэс дээдэс ба эгэл жир иргэдийг чандлан захирагсад зориулсан бүх хуулиудын анхных нь МЦБ-ээс уламжлалтай нь төсөрхөй. Харин МЦБ-ийг боловсруулахдаа Их Монгол Улсын "Их засаг", "Их цааз" болон монголчуудын өөрсдөө бүтээсэн бусад хуулиудын зарим заалтыг хэргэлэсэн байсныг өр үгүйсгэх аргагүй. Гэхдээ "МЦБ-ийн эх сурвалж болсон зүйлүүдийн нэг нь "Халх журам" байсан нь дамжиггүй" /4.113/ гэж үзэх нь эргэлзээтэй буюу байж боломгүй. Яагаад гэвэл судлаачдын нотолж байгаагаар бол "Халх журам"-ыг 1709 оноос анх эхлэн боловсруулсан байна. Өөрөөр хэлбэл МЦБ-ийг дагаж шийтгүүлсэн 1643 оноос даруй 166 жилийн дараа "Халх журам"-ыг тэр халхын хэлэг ноёд чуулж хөдөлцөн баталсан байна. Ингэхээр МЦБ-ийн анхны худалбар "Халх журам"-ын заалтыг тусгах ямар ч боломж үгүй юм. Гэхлүү хожмоо буюу 1643 оноос хойш МЦБ-т нэмэлт оруулахдаа "Халх журам"-ын зарим заалтыг тусгахын байсныг үгүйсгэх учиргүй билээ.

Мөн бас нэгэн зүйлийг энц гэмдэлэхэд манай судлаачдын дотроос эрдэмтэн С.Жалан-Аажав гэх 1989 онд хэвлүүлсэн нэгэн бүтээлдээ МЦБ-ийн тухай гэмдэллэсэн байна. Бас тэрбээр Манжийн тэр монголыг захирах тусгай хууль боловсруулахдаа "Монголчуудын өрт дээр цагаас уламжилсан хэс бэсн огт хайхрэхгүй байх чармагуй" /4.114/ гэж үзсэн нь нилээд үнэмшилтэй гэргалгаа болж байна. Харин С.Жалан-Аажав айтуй МЦБ-ийг анх 1789 онд боловсруулан дагаж шийтгүүлсэн гэж үзсэн нь татива мэт. Гэвч түүний энэ саналыг манай хэд хэдэн судлаач дэмжиж бүтээл туурвидаа шинжсэн байдаг.

МЦБ-ийг манай эрдэмтэд анхэн болтол тусгайлан шинжилсэн бүтээл туурвил хэвлүүлээгүй байгаа юм. Энэ нь ч зохих учир шалтгаантай билээ. Тодруулбал, 1911 онд тусгаар тогтнолоо сэргээсэн Монгол Улсын эрдэмтэн судлаачид манжийн үеийн түүхийн зарим асуудлыг зөвхөн хөндөх төдийгөөс бараг хөтөрсөнгүй. 1921 оноос хойш манай түүхчид, эрх зүйчид манжийн үед боловсруулсан нилээд хуулийг өнгөц судалж бүтээл туурвилдаа хааяа эш татахаар илгээрлэгдэж байв. Үүний шалтгаан нь сурвалж баримт судалгааны эргэлтэнд орж амжаагүйтэй холбоотой. Мөн манжийн төрөөс монголын тухайд баримталсан бодлогыг олон талаас нь урттай шинжлэхэд судалгааны газрууд, эрдэмтдийн аль аль нь төдийлэн анхаарч байгаагүй явдал хоёрдогч шалтгаан болно.

Гэвч 1990 оноос хойш монголын түүхчид, эрх зүй судлаачид эх түүхээ боловсруулахад санаа тавьж үнд эмнэ нь бага судалсан, огт хөндөөгүй, ташаа байдлаар дүгнэсэн олон эрдвийг эрхлэн судлах болсноор нилээд үр дүнд хүрч байгааг хэн ч үл үгүйсгэх билээ. Ялангуяа эх сурвалжийг судлах, шинжилгээний эргэлтэд оруулах талээр нилээд ажил гарч байна. Тухайлбал төсөрхөн МУИС-ийн багш хуульч магистр Батсүхийн Баярсайхан хоёр бүтээл угсран хэвлүүлж олны хүртээл болговлоо. Нэг нь нэгөөгөө нөхөн тодруулсан эл хоёр бүтээлд зориулж би энэхүү хурвангүй шүүмжийг бичиж эрдэмтэн шинжээч Та бүхэнтэй санал бодлоо солилцуулахын сацуу залуу судлаачийн нэр хичээнгүй хөдөлмөр шингэсэн эдгээр бүтээлд сэтгэл тун ч хангалуун байгаагаа зориуд цохон тэмдэглэж байна.

Өгүүлэхүй нь: 2001 онд Б.Баярсайхан "Монгол цаазын бичиг" /харьцуулсан судалгаа/ хэмээх 419 нүүр бүхий бүтээлээ нийтлүүлсэн бөгөөд түүний гол зорилго нь 1620-иод оноос эхлэн манжийн төр мөхөх хүртлээ монголын талаар баримталсан бодлогоо хэрэгжүүлэх гол хэрэгсэл болсон хуулиуд түүний дотор "Монгол цаазын бичиг"-ийг манжийн ба монголын хуулиудтай харьцуулан судлахад чиглэжээ.

Тэрбээр зохиолынхоо эхний хэсэгт гадаадын ба монголын эрх зүйч, түүхэнд энэхүү хуулийг хэзээ хэрхэн судалсныг тогтож өгүүлээд үе үеийн шинжээчид МЦБ-ийг чухам хэзээ боловсруулсан дагаж шийтгүүлсэн талаар харилцан адилгүй саналтай байдгийг дурдаад зарим эрдэмтэний үзэж байгаагаар бол 1662-1722 оны хооронд түүнийг боловсруулж мөрдүүлсэн аж. Нөгөө хэсэг нь 1789 оноос эхлэн уг хуулийг мөрдүүлэх болсон байна. /2.22-23 дахь талд үз/ гэжээ. Б.Баярсайхан МЦБ-ийг 1636-1643 оны үед буюу Дээд эрдэмтэний хаанчлалын үед хамааруулж болохыг үгүйсгэх аргагүй боловч үүнийг нотлох "тодорхой баримт бараг үгүй тул нийтийн он тооллын 1662 оноос хойш тогтоон мөрдүүлсэн гэсэн ойлголттой санаа нэг байна" /2.24/ гээд 1789 онд МЦБ-ийг "батлан гаргаагүй гэдэг" саналыг дэмжиж байгаагаа тэмдэглэж зохих нотолгоо гаргасан байна.

Б.Баярсайхан энэхүү МЦБ-ийг анх боловсруулсан, дагаж мөрдүүлсэн хугацааны тухайд өөрийнхөө баримталж буй санааг нилээд тодруулж 2004 онд хэвлүүлсэн "Монгол цаазын бичиг" /эх бичгийн судалгаа/ /376 нүүр/ хэмээх бүтээлийнхээ оршилд дахин өгүүлж зарим тодруулга хийжээ. Тухайлбал түүний ажигласнаар энэхүү хуулийг анх 1636 онд боловсруулан даган шийтгүүлсэн боловч 1736-1794 онуудын хооронд удаа дараа "идэвхтэй өөрчлөн найруулж байсан" /3.12/ нь уг хуульд өгүүлж буй огнооноос тодорхой мэдэгдэж байна гэжээ.

Б.Баярсайхан уг хуулийг анх 1636 онд боловсруулж мөрдүүлэх болсон гэдэг санааг үгүйсгэхгүй байгаагаа 2001 онд бичсэн бүтээлдээ дурдсан боловч чухам яагаад ингэж үзэх боломжтойгоо төдий л тодорхой гаргаагүй байлаа. Гэвч түүнээс хойш уул асуудлыг улам бүр анхаарч судлаачдын бүтээл туурвилыг сайтар уншиж эргэцүүлэн ажиглалт хийсэн байна. Тухайлбал, 1979 онд БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны төр засгийнхны санал болгосноор 1980-1989 онд хэсэг эрдэмтдийн туурвисан "Монгол үндэстний нэвтэрхий түүх" хэмээх гурван дэвтэр 2096 хуудас бүтээлд "Монгол цаазын бичиг"-ийг Дээд эрдэмтэний наймдугаар 1643 онд албан ёсоор тархаажээ гэсэн мэдээнд тулгуурлан хойд Алтан Улсын хоёр дахь эзэн Абахай хаанчлалын хамгийн сүүлчийн жилээс уг хуулийг дагаж мөрдүүлэх болжээ хэмээн өгүүлсэн байгааг /3.12/ тэмдэглэжээ. Судлаач Б.Баярсайхан МЦБ-ийг ингэж 1643 оноос эхлэн албан ёсоор тархаасан буюу шийтгүүлжээ гэж үзэж буй эрдэмтэдийн саналыг дэмжсэн байна. Үүнээс үзвэл МЦБ-ийн 2001 онд хэвлүүлсэн бүтээлдээ Б.Баярсайхан МЦБ-ийг 1622 оноос хойш тогтоон мөрдүүлсэн гэж үзэж байсныгаа хянуур нягталж 1643 оны үед хамааруулах нь зөв хэмээн ойлгосон нь тодорхой байна. Би хувьдаа үүнийг дэмжихийн сацуу 1643 оноос ч өмнө буюу 1636-1643 оны хооронд л МЦБ-ийн анхны хувилбарыг боловсруулсан байх ёстой гэж дээр дурдсан санаагаа үнэмжилтэй гэж бодож байгаа юм. Гэвч судлаачид цааш нь нэхэн нягтлах буй за.

Б.Баярсайхан 2001 онд хэвлүүлсэн бүтээлдээ урьд өмнө нь судлаачид ер ажиглаагүй байсан бас нэгэн шинэ зүйл тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, МЦБ-т нийтдээ 32 удаа "нэмэлт өөрчлөлт оруулан мөрдүүлж байжээ гэх үндэстэй юм" /2.23/ гэж өгүүлээд тэдгээр 32 нэмэлт өөрчлөлтийг чухам хэзээ хэдийд оруулсан огноог дурдаагүй байсан бол 2004 онд нийтлүүлсэн бүтээлдээ удаа дараа оруулсан нэмэлт өөрчлөлтийг нэг бүрчлэн жагсаахдаа ихэнхийнх нь он, сар, өдрийг тэмдэглэсний сацуу нэмсэн зүйлийн агуулгыг товч хураангуй ойлгомжтойгоор өгүүлсэн байна. Үүнийг бэлтгэхийн тулд МЦБ-ийг нилээд

нарийвчлан судалж үлэмж цаг хугацаа уйгагүй хөдөлмөрөө зориулсан нь лавтай. Эдгээр өөрчлөлтөөс үзвэл манжийн төр МЦБ-ийг анх боловсруулсанаасаа хойш 40 гаруй удаа нэмэлт оруулж, уг хуулийн заалтыг улам бүр чанд хатуу болгож байсан нь тодорхой байна.

Мөн эдгээр өөрчлөлтийн тухай мэдээнд тулгуурлаж бас нэгэн шинэ гаргалгаа хийх боломж бүрдэж байгааг зориуд тэмдэглэж судлаачдад сонордуулах нь илүүц бус төдийгүй сонин байж ч магадгүй. Тухайлбал, 1789 онд МЦБ-ийг үндэс болгож ЗТГМТЗЯЯХЗБ хэмээх 209 зүйл бүхий хуулийг дагаж шийтгүүлсэн гэж олон судлаачид бичсэн байдаг боловч МЦБ-ийг мөрдүүлэхээ зогссон эсэх талаар ер дурдаагүй байдаг. Тэгвэл миний санахад 1789 оноос хойш зургаан жил орчим хугацаанд буюу 1794 оны өвлийн тэргүүн сарын шинийн дөрвөний өдөр хүртэл МЦБ хүчин төгөлдөр байсан нь лавтай төдийгүй 1789 оны 10 сараас 1794 оны өвлийн тэргүүн сар хүртэл МЦБ-т 11 удаа нэмэлт оруулсан байна. /3.15-16 дахь талд үз/ Үүнээс улбаалан энэ хоёр хуулийг зэрэгцүүлэн мөрдүүлж байжээ гэж үзэхэд эргэлзэх зүйлгүй мэт. Мөн энэ дашрамд тэмдэглэхэд Манж Дайчин Улсын төр 1620-иод оноос 1911 онд Монголчуудад зориулж чухам хэдэн хууль боловсруулж мөрдүүлсэн ба тэдгээрт ямар ямар өөрчлөлт оруулж байсныг тусгайлан судлахгүйгээр Монголын эх түүхийг ялангуяа, манжийн үеийн түүхийг бүрэн боловсруулах боломжгүй билээ.

Б.Баярсайхан 2001 онд хэвлүүлсэн бүтээлдээ МЦБ-ийн агуулгыг таван дэд сэдэвт хувааж судалсан нь зөвхөн эрх зүйчид төдийгүй монголын түүх, угсаатны зүйл, шашны зан үйлийн уламжлал хувьсал өөрчлөлтийг мөшгөн шинжлэгчид, сонирхогчдын эрэлт хэрэгцээг хангахуйц чамбай болсон байна. Б.Баярсайханы судалгааг ажиглаж байхад манжийн төр шашны хуврагуудын талаар нилээд чанга журам баримталж түүнийгээ МЦБ-т тусгай зүйл болгон оруулсан байжээ. Жишээлбэл, нийт монголчуудын уугуул бөөгийн шашны зарим зан үйлийг Түмэдийн Алтай ханы санаачлагаар хязгаарлах болсныг МЦБ-т хуульчлан "үхсэн хүнд морь бүү алагтун" /2.80/ гэж заасан байна.

Монголчууд шашин шүтэх, эс шүтэхийн аль алиных нь тухай МЦБ-т тодорхой заалт үгүй боловч нэгэнт лам болсон хуврагуудын дагах ёс журам өмсөх хувцасны өнгийг хүртэл тул хуульд тодорхойлоод үүнийг зөрчсөн хуврагт ногдуулах шийтгэл /торгох, занчих/-ийг заасан байна. Мөн хэн хүн зохих эрх мэдэлтэний зөвшөөрөлгүйгээр лам, банди болохыг чанд хоригложээ. Үүнээс гадна Монголын зарим томоохон сүмд цуглаж ном унших лам нарын тоог 400-гаар хязгаарлаж, түүний зардалд зориулж 1000 лан мөнгийг улсын сангаас гаргаж байх тухай заалт байгааг Б.Баярсайхан тодруулан тайлбарлажээ. /2.80/ Бас цэргийн хүн буюу хуяг өмсгөсөн эр, төр, захиргааны байгууллагад албан тушаалтай хүмүүс сахил хүртэж увш болохыг хориглосноос гадна гадаад ба өвөр монголын эхнэр бүсгүйчүүд өөрийнхөө ял шийтгэл хүлээлгэхээр заажээ. /2.187/ Эдгээр заалт нь монголчуудын тусын тулд бус зөвхөн манж Дайчин улсын "хос төр"-ийг өнө үүрд хүчирхэг байлгах хэмээсэн ганц зорилгод чиглэснийг тайлбарлаагүй билээ.

Манжийн хааны эрх хэмжээ, Манжийн төрөөс Монголд хэрэгжүүлж байсан санхүүгийн бодлого, эрүүгийн эрх зүйн янз бүрийн асуудал, иргэн гэр бүлийн тухай МЦБ-т буй олон заалтыг Б.Баярсайхан бусад хуулиудтай жишин харьцуулж үнэмшилтэй цэгцтэй дүгнэлт гаргалаа хийсэн байна.

Б.Баярсайхан энэ номынхоо сүүлчийн хэсэгт нь МЦБ-ийн 12 дэвтэрийн 206 зүйлийг кирилл ба галиг /транслитерация/-аар бичиж хавсаргасны сацуу албан тушаал, зэрэг хэргэм, албан татвар, бичиг баримт, засаг захиргааны нэгж, төрийн байгууллага, хүний нэр, гэмт хэрэг зөрчил, ял шийтгэл, хаан, хан ба оны цол зэрэг арван сэдэвт холбогдох олон үгийн хэлхээг жагсааж хуудасны дугаар тэмдэглэсэн нь хэн хүн өөрийн сонирхсон зүйлээ хялбархан олох боломжтой болжээ.

Б.Баярсайхан МЦБ-ийг 2001 онд хэвлүүлснээсээ хойш түүнийг гүнзгийрүүлэн судалж зарим шинэ гаргалгаа хийснээ 2004 онд нийтлүүлсэн бүтээлдээ дурдсаныг би өмнө өгүүлсэн дээрээ нэмж бас нэгэн зүйлийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзсэн юм. Энэ бол МЦБ-ийн 12 дэвтрийн бүх хуудсыг факсимле-ээр хэвлэж үг бүрийг галиг ба кирилл бичгээр буулган дэргэд нь хавсаргаснаар уг сурвалжийг жинхэнэ эхээр нь унших боломжтой болгожээ. Ялангуяа уйгаржин монгол бичиг уншихдаа тийм ч сайн бус хүмүүс, гадаадын монгол судлаачдад энэ ном хэд хэдэн зүйлээр тус дөхөм үзүүлэхүйц чамбай бүтээл болжээ. Мөн уг хуульд байгаа олон үгийг галиг үсгийн буюу латин үсгийн дарааллаар жагсаан хавсаргасан нь уг бүтээлийг уншиж судлах тодорхой зүйл сонирхож буй хүн эрсэн сэдвээ холбогдох үгээр нь хөөж олоход ихээхэн дөхөм болохуйц байна.

МЦБ-ийг Бээжинд барласан бүрэн дэвтэрүүд манай улсын Үндэсний төв архив, Улсын нийтийн номын санд хадгалж байдгийн нэг эхийг нь Б.Баярсайхан ийнхүү судлан хэвлүүлсэн нь эх түүхийн сурвалж судлалын хичээл үздэг Их сургууль, коллежуудад гарын авлага болгон ашиглах бүрэн боломжтойг эцэст нь тэмдэглээд, маш эрчтэй үргэлжлүүлж буй судалгаа шинжилгээ чинь улам бүр чамбайран арвижиж байхыг залуу судлаач Б.Баярсайхандаа ерөөе.

Ном зүй

1. Баркманн Удо Б. Түүх судлалд хавсрага ухааны ач холбогдлын тухай-Түүхийн хавсрага ухаан УБ. 2003. 6
2. Баярсайхан Б. Монгол цаазын бичиг. /Харьцуулсан судалгаа/ УБ. 2001
3. Баярсайхан Б. Монгол цаазын бичиг /Эх бичгийн судалгаа/ УБ. 2004
4. Жалан-Аажав С. Халх журам бол Монголын хууль цаазын эртний дурсгалт бичиг . УБ. 1958